



3

**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 02 сарын 14 өдөр

Дугаар A/02

Улаанбаатар хот

Г Ёс зүйн байнгын хороонд өөрчлөлт Г
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоол, "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм", Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албаны Ёс зүйн хорооны гишүүнээр Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ч.Цог, Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн Д.Жаргалсайхан, Гэр хорооллын дулаан хангамж хариуцсан мэргэжилтэн Д.Санчирбаяр нарын гурван хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, зөвлөлийн даргаар нь Ч.Цогийг томилон ажиллуулсугай.

2. Албаны үйл ажиллагаанд "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, "Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам", "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийг мөрдлөг болгон ажиллахыг Ёс зүйн хороо /Ч.Цог/-нд үүрэг болгосугай.

3. Албаны дэргэд төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргаж, нийт албан хаагчдад энэ талаар гарсан хууль тогтоомжийг судлан, мөрдлөгө болгон ажиллахыг Ёс зүйн хороо /Ч.Цог/-нд үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарч мөрдөгдөх болсонтой холбогдуулан 2013 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн Б/26 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН